

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	3
2. Аудитын тайлан.....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал .....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	13
4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	15
4.3. Аудит хийсэн цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн тайлан .....	17
4.4. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	18
4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	20
4.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	23
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	24

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
GIZ	Германы Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Н.ЭРДЭНЭХҮҮ ТАНАА

2020.02.27 № 06/636  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хавдар судлалын үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Хавдар судлалын үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хавдар судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга Хавдар судлалын үндэсний төвд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Хавдар судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Ерөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Эрдэнэхүү Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн дотоод аудит, худалдан авалтын гэрээ, хандив, тусламжийн орлого, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, эрүүл мэндийн даатгалын сангийн талаарх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хавдар судлалын үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хавдар судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 24-нээс 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, тус компанийн ерөнхий захирал Ц.Сугармаа, аудитор Г.Эрдэнэчимэг, аудиторын туслах Э.Сайнзаяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хавдар судлалын үндэсний төв 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 01/165 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Хавдар судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Үндэсний хэмжээнд хавдрын мэргэжлийн тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчид ээлтэй, чанартай, тэгш хүртээмжтэй үзүүлэхэд манлайлагч байх”-д оршино.

Хавдар судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хавдрын нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх;

Тайлант хугацаанд Хавдар судлалын үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хавдар судлалын үндэсний төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хавдар судлалын үндэсний төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acoulous 3.0 программ хангамж ашигладаг байна.

Хавдар судлалын үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Хавдар судлалын үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 9 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлын дүнгээс сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 29,152,660.7 мянган төгрөгөөс тооцон 291,526.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитын гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөлт ороогүй болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хавдар судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,485,017.7 мянган төгрөгөөр буюу 52.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр болон эздийн өмчийн данс байна.

### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		5,523.3	5,523.3
Авлага	113,538.9	15,582.4	(97,956.5)
Бараа материал	2,062,144.9	1,753,210.0	(308,934.9)
Үндсэн хөрөнгө	25,579,415.3	40,465,801.1	14,886,385.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>27,755,099.1</b>	<b>42,240,116.8</b>	<b>14,485,017.7</b>
Өр төлбөр	0,0	5,792.0	5,792.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	27,755,099.1	42,234,324.8	14,479,225.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>27,755,099.1</b>	<b>42,240,116.8</b>	<b>14,485,017.7</b>

Авлага дансны эхний үлдэгдэл 113,538.9 мянган төгрөг байснаас өмнөх онд дуусаагүй байсан 60,000.0 мянган төгрөгийн гэрээт ажлыг хийж дуусгаж, 53,538.9 мянган төгрөгийг санхүүгийн ном хэвлүүлэх, хавдраас урьдчилан сэргийлэх буюу эрт илрүүлэлтийн тогтолцоонд молекул генетик оношилгооны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх судалгааны ажлын дутуу 5,050.1 мянган төгрөг, нэмэлт төсвийн данснаас улсын төсөвт төвлөрүүлсэн 10,532.3 мянган төгрөгийг тайлант жилийн эцсийн үлдэгдлээр тусгасан байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 2,062,144.9 төгрөг байснаас тайлант жилд 14,472,678.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, 14,781,613.4 мянган төгрөгийг бараа материалыг зарцуулан 1,753,210.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хангамжийн материалд эмнэлгийн ажилчдын хувцас, ор хөнжлийн даавуу болон бусад жижиг багаж хэрэгслүүд ордог бөгөөд энэ нь нийт бараа материалын үлдэгдлийн 61.8 хувийг эзэлж байна. Мөн Эрүүл мэндийн сайдын 2009 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 388 дугаар тушаалаар өгсөн зөвлөмжийн дагуу эмнэлгүүд үйл ажиллагааны онцлогтой уялдуулан тусламж үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг бэлтгэж 668,353.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 25,579,415.3 мянган төгрөг байсан бөгөөд тайлант жилд хөрөнгө оруулалтаар 18,362,180.9 мянган төгрөг, хандив тусламжаар 128,221.4 мянган төгрөг, улсын төсвийн санхүүжилтээр 37,014.7 мянган төгрөг, хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний нэмэлт эх үүсвэрээр 106,328.5 мянган төгрөг нийт 18,663,745.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/2/2604 тоот зөвшөөрөл, А/5/2611 тоот албан бичгийг тус тус үндэслэн 336,881.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, 3,440,478.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцож, тайлант оны эцэст 40,465,801.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл нэмэгдсэн нь Цусны төвөөс 5,792.0 мян төгрөгийн цус, цусан бүтээгдэхүүн авсантай холбоотой байна.

Эздийн өмчийн дүн тайлант үеийн үр дүн болох 14,479,225.7 мянган төгрөгөөр нэмэгджээ.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хавдар судлалын үндэсний төвд тайлант онд нийт 24,544,983.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 24,338,432.1 мянган төгрөг буюу 99.1 хувь байна.

Үүнээс үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 3,894,908.5 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 4,051,307.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 104.0 хувиар биелүүлжээ.

ЭМД-ын санхүүжилтийн орлого нийт 9,609,932.5 мянган төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 9,243,982.1 мянган төгрөгийн санхүүжилт авч 365,950.4 мянган төгрөгөөр тасарч 96.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Урсгал зардлыг санхүүжүүлэхэд 24,332,908.7 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд цалин хөлс, нийгмийн даатгалд 8,911,107.5 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний зардалд нийт 15,344,765.2 мянган төгрөгийг зарцуулан 77,036.1 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Хандив тусламжаар 18,438.7 мянган төгрөг, гадаадын төсөл хөтөлбөрөөс 154,830.1 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 121,142.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 508,849.1 мянган төгрөг, нийт 803,260.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлсөнд 200,610.1 мянган төгрөг, хангамжийн материалд 61,236.6 мянган төгрөг, нормативт зардалд 135,766.0 мянган төгрөг, багаж техник засвар үйлчилгээнд 158,950.0 мянган төгрөг, гадаад болон дотоод томилолтын зардалд 48,115.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 9,905.8 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээнд 178,143.9 мянган төгрөг буюу нийт 792,727.6 мянган төгрөгийг зарцуулан үлдэгдэл 10,532.3 мянган төгрөгийг татан төвлөрүүлжээ.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 9 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл нэмж тодорхойлон нийт 17 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 9,414,065.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 9,260,824.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 153,241.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг менежментийн захидалд тусгалаа.

Хоол хүнсний зардлыг (дансны код: 210502) цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлын дансанд (дансны код: 210104) бүртгэсэн 16,841.9 мянган төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг тусламж, үйлчилгээний орлогоор бүртгэж, зардлын эдийн засгийн ангиллыг зөрүүтэй бүртгэсэн 9,243,982.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь Сангийн сайдын 2015 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалын II хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Аудитын явцад санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланг залруулав.

Ханган нийлүүлэгч 4 байгууллагатай хийсэн тендерийн гэрээний дүнгээс 153,241.8 мянган төгрөгөөр илүү худалдан авалт хийсэн нь тендерийн гэрээний нөхцөлийн "гэрээний үнийн дүнгийн 20 хувиас хэтрэхгүй" гэсэн заалтыг тус тус зөрчиж байгаа нь тогтоосон материаллаг байдлын түвшингээс илүү, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага хүргүүлэх.



Аудитаар илэрсэн дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээ, эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалт болон анхан шатны баримтын хөтлөлтийн талаар 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг шалгах аас гадна даарах асуудалд анхаарал хандуулж ажиллах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- Тайлант онд 12 ханган нийлүүлэгч байгууллагатай 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс 03 дугаар сарын 31-ний хооронд нийт 780,543.1 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах тухай нэмэлт гэрээг хийсэн.

Энэхүү гэрээгээр нийлүүлэгдсэн эм, эмнэлгийн хэрэгслүүд нь өмнөх гэрээгээр нийлүүлэгдэж байсан бөгөөд онцгой тохиолдолд бэлтгэх онц шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэлд хамаарахгүй байна. “Нэмэлт гэрээ” гэх шууд худалдан авах тухай гэрээний үндэслэл болгож байгаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.7-д заасан **“хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зарим онцгой эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах шаардлагатай гэж үзсэн”** болон Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан босго үнийн жишиг болох “Шууд гэрээ хийхэд худалдан авах барааны төсөвт өртгийн дээд хязгаар 10.0 сая төгрөг, харьцуулалтын аргаар худалдан авах төсөвт өртгийн дээд хязгаар 50.0 сая төгрөг байх” гэсэн заалтуудыг зөрчсөн алдаа зөрчлүүд;

- Ханган нийлүүлэгч байгууллагуудтай хийж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг зохион байгуулахдаа хэд хэдэн хэсэгт хуваах, эсвэл тайлант онд хамааруулахгүй он дамжуулан тендер зохион байгуулан хууль зөрчиж байгаа нь сөрөг үр дагаврыг дагуулж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн зааврын **“Санхүүгийн тайлангийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно”** гэснийг тус тус зөрчиж байна. Иймд байгууллагын удирдлага нь санхүүгийн жилийн хүрээнд худалдан авалтын ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахын тулд өмнөх онд багтаан эм, эмнэлгийн хэрэгслийн нээлттэй тендерийг зохион байгуулах, түүнд шаардагдах хугацааг нарийн тооцож, нягтлан бодох бүртгэлийн алдааг дахин гаргахгүй байх арга хэмжээ авч ажилласан талаар гол анхаарал хандуулах болно.

## 2.12. Шилэн дансны мэдээлэл

Хавдар судлалын үндэсний төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан тайлант хугацаанд өмнөө тавьсан зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой 8, худалдан авалт түүний гүйцэтгэлтэй холбоотой 9, зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн талаар 6 нийт 23 мэдээллийг байршуулжээ.

## 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага, 4 зөвлөмж өгч зөвлөмжийн биелэлт 100.0 хувьтай байна.

## 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хавдар судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 153,241.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь төлөвлөлтийн үе шатанд тооцсон материаллаг түвшингийн дүнгээс бага тул Хавдар судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1. **Анхан шатны баримттай холбоотой асуудал**

3.1.1. Илрүүлэлт: Хүчингүй болсон Санхүү, Эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 171/111 тоот тушаалаар баталсан анхан шатны баримтуудаар нягтлан бодох бүртгэл хөтөлж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг тус тус зөрчиж байна.

3.1.2. Эрсдэл: Холбогдох хууль тогтоомжийг мөрдөөгүй байх;

3.1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх заалт “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлөлт, санхүүгийн тайлан, үнэн зөв, гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Маягт, заавар батлах тухай” журмыг мөрдөж ажиллах;

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллана.

#### 3.2. **Дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээтэй холбоотой асуудал**

3.2.1. Илрүүлэлт: Дотоод аудитор нь байгууллагын үйл ажиллагаанд гарч болох ямар нэгэн эрсдэлтэй асуудалд чиглэсэн аудитыг хийж, дүгнэлт гарган зөвлөмж өгөх ба түүнийг эргэн хянаснаар дотоод аудитын үр нөлөөг сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллах. Тухайлбал: Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 365 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагаанд дотоод аудит хийх журам”-ын 2.1, 3.5, 3.7-д заасны дагуу жил бүр худалдан авах ажиллагаанд дотоод аудит хийж, үр дүнг тооцож, зөвлөмж гаргаж ажилласан талаар ажлын баримт материалгүй байна.

3.2.2. Эрсдэл: Холбогдох хууль, дүрэм журам мөрдөж ажиллаагүй байх;

3.2.3. Өгсөн зөвлөмж: Тухайн жилийн худалдан авалтын төлөвлөгөөг үндэслэн эрсдэлд чиглэсэн дотоод аудитыг журмын дагуу хийж, дүгнэлт гаргах;

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллана.

### **3.3. Эрүүл мэндийн даатгалын сантай холбоотой асуудал**

3.3.1. Илрүүлэлт: Acolous 3.0 програмд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байгаа орлогыг хандив, тусламжийн орлого нэрээр бүртгэснээс санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний болон төсвийн гүйцэтгэлийн тайлангууд зөрүүтэй гарч байна. Энэ нь Сангийн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалаар баталсан “Эдийн засгийн ангилал батлах тухай” журмын 3 дугаар хавсралтаар баталсан зардлыг санхүүжүүлэх эдийн засгийн ангиллын” нэрээр ангилж бүртгэх гэсэнтэй нийцэхгүй байна.

3.3.2. Эрсдэл: Хөрөнгө иж бүрэн, үнэн зөв бүртгээгүй байх;

3.3.3. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 7 дугаар тушаалаар баталсан “Эдийн засгийн ангилал батлах тухай” журмыг мөрдөж ажиллах;

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллана.

### **3.4. Өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгсэлтэй холбоотой асуудал**

3.4.1. Илрүүлэлт: Өндөр өртөгтэй хэрэгслийн зарцуулалтын түүврийн баримт нь хяналт тавьсан санхүүгийн ажилтны гарын үсэггүй, зөвхөн хагалгааны сувилагч, ахлах сувилагчийн гарын үсэгтэй байгаа, мөн харандаагаар бүртгэл хөтөлсөн, засвартай, ашиглагдаагүй буцаасан хэрэгслийг баримтгүйгээр шууд зардлаар бүртгэсэн зэрэг нь бараа материалын тайланд илүү зарцуулалт гарах, зарцуулалтын түүврийг өвчтөн тус бүрээр тулгахад зөрүүтэй байна.

3.4.2. Эрсдэл: Анхан шатны баримтыг бүрэн хөтлөөгүй байх;

3.4.3. Өгсөн зөвлөмж: Өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгслийг Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Анхан шатны маягыг хөтлөх заавар”-ын Шаардах хуудсаар мэс ажилбарт орж байгаа хүн нэг бүрээр, мөн хэрэглэгдээгүй буцаагдсан хэрэгслийг шаардах хуудсаар бүртгэж баримтжуулж байх;

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,175,683,784.17</b>	<b>1,774,315,721.78</b>
<b>2</b>	<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	<b>(0.00)</b>	<b>5,523,338.00</b>
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	(0.00)	-
9	Төгрөг	(0.00)	-
10	Төрийн сангийн харилцах	(0.00)	-
14	Нэмэлт санхүүжилтийн харилцах	(0.00)	-
21	Замд яваа мөнгөн хөрөнгө	-	5,523,338.00
<b>27</b>	<b>АВЛАГА</b>	<b>113,538,900.00</b>	<b>15,582,370.00</b>
28	Ажиллагсадтай холбогдсон авлага	-	4,450,000.00
30	Татаас санхүүжилтийн авлага	53,538,900.00	10,532,370.00
34	Бусад авлага	60,000,000.00	600,000.00
35	Байгууллагаас авах авлага	60,000,000.00	600,000.00
<b>60</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>2,062,144,884.17</b>	<b>1,753,210,013.78</b>
61	Түүхий эд материал	842,937,130.49	668,353,651.50
63	Эм боох материал	842,937,130.49	668,353,651.50
66	Хангамжийн материал	1,219,207,753.68	1,084,856,362.28
67	Бичиг хэргийн материал	10,449,700.00	13,075,442.00
68	Аж ахуйн материал	26,924,000.00	21,062,000.00
71	Барилгын засварын материал	42,407,800.00	3,495,100.00
72	Хүнсний материал	14,353,196.30	16,635,770.30
73	Бусад хангамжийн материал	1,125,073,057.38	1,030,588,049.98
<b>86</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>25,579,415,274.37</b>	<b>40,465,801,127.32</b>
<b>106</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>25,579,415,274.37</b>	<b>40,465,801,127.32</b>
<b>108</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>24,274,622,694.50</b>	<b>38,299,900,629.59</b>
109	Барилга, байгууламж	17,901,182,207.00	18,538,590,221.30
110	Хуримтлагдсан элэгдэл	(210,613,487.19)	(807,585,665.95)
111	Авто тээврийн хэрэгсэл	312,862,000.00	435,830,041.00
112	Хуримтлагдсан элэгдэл	(286,894,639.20)	(317,851,755.14)
113	Машин, тоног төхөөрөмж	19,918,994,223.08	36,571,548,940.78
114	Хуримтлагдсан элэгдэл	(13,742,846,916.82)	(16,459,003,177.18)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	786,139,688.69	771,230,668.04
116	Хуримтлагдсан элэгдэл	(476,411,564.79)	(496,919,594.34)
122	Бусад үндсэн хөрөнгө	247,024,912.31	247,024,912.31
123	Хуримтлагдсан элэгдэл	(174,813,728.58)	(182,963,961.23)
<b>126</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,304,792,579.87</b>	<b>2,165,900,497.73</b>
127	Програм хангамж	202,171,939.00	1,101,014,114.20
128	Хасагдуулга	(201,829,439.13)	(239,563,696.47)
129	Бусад биет бус хөрөнгө	1,304,450,080.00	1,304,450,080.00
<b>137</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>27,755,099,058.54</b>	<b>42,240,116,849.10</b>
<b>138</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>5,792,005.00</b>
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	5,792,005.00
164	Өглөг	0.00	5,792,005.00
165	Ажиллагчидтай холбогдсон өглөг	0.00	0.00
170	Бусад өглөг	0.00	5,792,005.00
171	Байгууллагад төлөх өглөг	0.00	5,792,005.00
<b>214</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>27,755,099,058.54</b>	<b>42,234,324,844.10</b>
215	Засгийн газрын хувь оролцоо	27,755,099,058.54	42,234,324,844.10

Хавдар судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	18,948,084,398.38	18,948,084,398.38
217	Өмч: -Төрийн өмч	18,948,084,398.38	18,948,084,398.38
223	Хуримтлагдсан үр дүн	(2,196,617,329.23)	12,283,650,904.39
КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
224	Өмнөх үеийн үр дүн	(2,196,617,329.23)	(2,195,574,881.17)
225	Тайлант үеийн үр дүн	-	14,479,225,785.56
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,003,631,989.39	11,002,589,541.33
<b>231</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨӨМЧИЙН ДҮН</b>	<b>27,755,099,058.54</b>	<b>42,240,116,849.10</b>

#### 4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН /төгрөг/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	22,305,060,734.04	43,631,886,524.43
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,678,389,055.04	22,595,040,441.11
77	Нийтлэг татварын бус орлого	3,678,389,055.04	22,595,040,441.11
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	3,678,389,055.04	3,924,647,356.99
82	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,026,033,378.50	3,924,647,356.99
83	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	155,866,043.42	-
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	496,489,633.12	-
93	Төсөвт байгууллагын өөрийн орлого /туслах/	-	126,659,896.12
94	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Үндсэн хөрөнгө	-	18,490,402,358.00
95	Үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материал	-	53,330,830.00
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	18,626,671,679.00	21,036,846,083.32
112	Улсын төвлөрсөн төсвөөс	10,951,218,400.00	11,043,142,700.00
113	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,951,218,400.00	11,043,142,700.00
122	Нэмэлт санхүүжилтийн орлого	403,103,900.00	749,721,282.32
